



ЭМ ХАНГАМЖИЙН
БАЙГУУЛЛАГУУДАД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

Энхтайван найрамдлын ордон, Энхтайваны өргөн чөлөө,
3 дугаар хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас: 26 01 82, Цахим шуудан: info@mmra.gov.mn,

Цахим хуудас: www.mmra.gov.mn

2026.09.18 № 01/1462
танай _____-ны № _____-т

Мэдээлэл хүргүүлэх тухай

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар нь эмийн бүртгэлийн “Лайсмед” программыг шинэчлэн, “Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын нэгдсэн систем” (pmd.hdc.gov.mn)-ийн хөгжүүлэлтийг хийж байна.

Тус системд тусгай зөвшөөрлийн чиглэл нэмэх, импорт, экспортын мэдүүлэг, эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл, лабораторийн шинжилгээ, байгууллага хоорондын цахим мэдээллийн нэгдсэн сангийн хөгжүүлэлтийг хийж дууссан.

Иймд импортын мэдүүлэг, эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл, лабораторийн шинжилгээний хүсэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн “Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын нэгдсэн систем” (pmd.hdc.gov.mn) -ээр хүлээн авахыг мэдэгдэж байна.

Системийг ашиглах сургалт 2026 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын 1 давхрын хурлын зааланд болно. Цахимаар оролцох байгууллагууд дараах зүүмээр хамрагдана уу.

Зүүм хаяг:

Meeting ID: 648 612 7972

Passcode: 123456

Хувийг: "Монголын эм зүйн байгууллагуудын нэгдсэн эм холбоо" ТББ -д

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



П.АЛТАНЦЭЦЭГ

1526 151440